



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/37/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Х.Билэгбаяр Утас: 94009818 Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 45

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,691,134.71</u>	<u>53,708,530.96</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	5,899,266.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	5,899,266.13
3121	Төгрөг	-	5,899,266.13
31211	Төрийн сангийн харилцах	-	2,814,512.13
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	3,084,754.00
33	АВЛАГА	-	6,148,221.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	108,221.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	6,040,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,691,134.71	41,661,043.07
351	Түүхий эд материал	10,403,822.52	19,084,930.88
35130	Эм боох материал	10,403,822.52	19,084,930.88
354	Хангамжийн материал	17,157,312.19	20,446,112.19
35410	Бичиг хэргийн материал	563,600.00	536,000.00
35420	Аж ахуйн материал	13,847,682.19	17,144,632.19
35440	Түлш, шатах тослох материал	692,100.00	692,100.00
35460	Хүнсний материал	2,001,930.00	2,073,380.00
35600	Мал амьтад	2,130,000.00	2,130,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>503,033,479.21</u>	<u>472,644,423.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	503,033,479.21	472,644,423.92
392	Биет хөрөнгө	500,535,479.21	470,146,423.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	377,979,718.21	377,979,718.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,122,677.96)	(28,772,264.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,576,434.00	34,276,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,386,253.26)	(26,602,325.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	245,434,667.02	284,849,762.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	(145,423,510.83)	(196,878,903.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,869,759.00	30,869,759.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,311,406.97)	(13,539,506.59)
39209	Зам, гүүрийн байгууламж	8,800,000.00	8,800,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(879,999.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	600,000.00	600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(481,250.00)	(556,250.00)
393	Биет бус хөрөнгө	2,498,000.00	2,498,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,498,000.00	2,498,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>532,724,613.92</u>	<u>526,352,954.88</u>

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	532,724,613.92	526,352,954.88
51	Засгийн газрын хувь оролцоо	532,724,613.92	526,352,954.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		280,690,937.20	280,690,937.20
51101	Өмч: - төрийн	280,690,937.20	280,690,937.20
512	Хуримтлагдсан үр дүн	(35,072,541.50)	(41,444,200.54)
51210	Өмнөх үеийн үр дүн	(35,072,541.50)	(35,072,541.50)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(6,371,659.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,106,218.22	287,106,218.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	532,724,613.92	526,352,954.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	335,321,370.00	539,222,746.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28107000.00	106379179.17
120	Нийтлэг татварын бус орлого	28107000.00	106379179.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28107000.00	106379179.17
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	28107000.00	71,655,483.32
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		34,723,695.85
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	307,214,370.00	432,843,567.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	260,392,500.00	322,533,500.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	260,392,500.00	322,533,500.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,250,000.00	78,241,057.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,242,300.00	22,866,057.00
131,105.00	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	775,000.00
131107	ЭМД-ын санхүүжилт		54,600,000.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,423,700.00	26,876,600.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,423,700.00	26,876,600.00
1,340.00	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,148,170.00	5,192,410.00
134,002.00	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,148,170.00	5,192,410.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	369,057,226.20	545,594,405.21
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	369,057,226.20	545,594,405.21
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,064,980.40	521,862,160.77
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,663,541.44	240,733,743.10
210,101.00	Үндсэн цалин	162,953,592.29	161,992,199.00
210,102.00	Нэмэгдэл	43,837,602.15	51,408,929.50

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	2,473,098.00	3,418,999.60
210,104.00	Урамшуулал	6,399,249.00	23,913,615.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,786,191.07	33,662,237.01
210,201.00	Тэтгэврийн даатгал	18,442,942.09	23,922,773.22
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,157,999.67	2,469,515.70
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,726,399.51	1,938,651.91
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	1,142,850.63	484,663.78
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,315,999.17	4,846,632.40
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,776,304.20	25,417,400.00
210,301.00	Гэрэл, цахилгаан	1,871,298.20	2,010,800.00
210,302.00	Түлш, халаалт	20,825,006.00	23,246,600.00
210,303.00	Цэвэр, бохир ус	80,000.00	160,000.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	13,751,290.00	19,419,490.00
210,401.00	Бичиг хэрэг	1,262,100.00	3,154,900.00
210,402.00	Тээвэр, шатахуун	10,200,000.00	13,000,440.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	508,300.00	638,150.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,669,890.00	2,551,000.00
210,407.00	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	75,000.00
2,105.00	Нормативт зардал	17,952,941.11	128,619,138.96
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,014,176.11	116,859,898.96
210,502.00	Хоол, хүнс	3,938,765.00	8,984,240.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,775,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	5,799,000.00	2,444,200.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	-	130,000.00
210,604.00	Урсгал засвар	5,799,000.00	2,314,200.00
2,107.00	Томилолт, зочны зардал	440,000.00	1,235,057.00
210,702.00	Дотоод албан томилолт	440,000.00	1,235,057.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	658,450.00	1,721,488.00
210,808.00	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	290,450.00	870,188.00
210,809.00	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,000.00	851,300.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	63,237,262.58	68,581,651.14
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,214,262.58	68,581,651.14
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	992,245.80	23,760,000.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	23,760,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	23,760,000.00
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(33,735,856.20)	(6,371,659.04)
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(33,735,856.20)	(6,371,659.04)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	280,690,937.20	287,106,218.22	-35,072,541.50	532,724,613.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,690,937.20	287,106,218.22	-35,072,541.50	532,724,613.92
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,371,659.04	-6,371,659.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,690,937.20	287,106,218.22	-41,444,200.54	526,352,954.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	307,214,370.00	426,803,567.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	307,214,370.00	426,803,567.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	260,392,500.00	322,533,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	260,392,500.00	322,533,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,250,000.00	72,201,057.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,242,300.00	22,866,057.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	775,000.00
131107	ЭМД-ын санхүүжилт		48,560,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,423,700.00	26,876,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,423,700.00	26,876,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,148,170.00	5,192,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,148,170.00	5,192,410.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,290,570.00	417,435,400.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,290,570.00	417,435,400.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,298,324.20	393,675,400.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,663,541.44	240,733,743.10
210101	Үндсэн цалин	162,953,592.29	161,992,199.00
210102	Нэмэгдэл	43,837,602.15	51,408,929.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,473,098.00	3,418,999.60
210104	Урамшуулал	6,399,249.00	23,913,615.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,786,191.07	33,770,458.77
210201	Тэтгэврийн даатгал	18,442,942.09	24,030,994.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,157,999.67	2,469,515.70

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,726,399.51	1,938,651.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,142,850.63	484,663.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,315,999.17	4,846,632.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,776,304.20	25,417,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,871,298.20	2,010,800.00
210302	Түлш, халаалт	20,825,006.00	23,246,600.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,435,200.00	22,894,190.00
210401	Бичиг хэрэг	1,352,400.00	2,569,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,200,000.00	13,000,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	508,300.00	638,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	111,000.00	898,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,263,500.00	5,787,300.00
2105	Нормативт зардал	13,955,037.49	62,976,364.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,830,637.49	52,185,864.00
210502	Хоол, хүнс	4,124,400.00	7,595,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,195,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,331,350.00	2,364,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	130,000.00
210604	Урсгал засвар	5,331,350.00	2,234,200.00
2107	Томилолт, зочны зардал	440,000.00	1,235,057.00
210702	Дотоод албан томилолт	440,000.00	1,235,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	887,700.00	2,501,488.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	290,450.00	870,188.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	273,250.00	1,631,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,023,000.00	1,782,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,023,000.00	1,782,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	992,245.80	23,760,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	23,760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	23,760,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,923,800.00	9,368,166.13
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,923,800.00	3,468,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,923,800.00	3,468,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,923,800.00	3,468,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,923,800.00	3,468,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,923,800.00)	(3,468,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	5,899,266.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,899,266.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,555,100.00	351,787,997.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,555,100.00	351,787,997.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,855,100.00	351,127,997.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,200,000.00	236,700,126.10
210101	Үндсэн цалин	168,000,000.00	161,548,137.00
210102	Нэмэгдэл	48,000,000.00	51,408,929.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,200,000.00	3,418,999.60
210104	Урамшуулал	21,000,000.00	20,324,060.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,102,000.00	32,275,477.77
210201	Тэтгэврийн даатгал	23,294,000.00	22,536,013.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,452,000.00	2,469,515.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,961,600.00	1,938,651.91
210204	Ажилгүйдлийн даатгал	490,400.00	484,663.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,904,000.00	4,846,632.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,276,600.00	25,276,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	2,000,000.00
210302	Түлш, халаалт	23,246,600.00	23,246,600.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,858,500.00	20,538,690.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,375,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,042,500.00	12,039,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,040,000.00	638,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	976,000.00	141,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	5,344,800.00
2105	Нормативт зардал	29,130,500.00	27,912,216.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,730,500.00	20,619,816.00
210502	Хоол, хүнс	5,600,000.00	5,597,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	1,695,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,454,900.00	5,198,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,854,900.00	3,598,900.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	684,000.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	684,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,300,000.00	1,331,488.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	200,188.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800,000.00	1,131,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,848,600.00	1,782,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,848,600.00	1,782,500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00	660,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	660,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	660,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	365,555,100.00	354,602,510.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	322,533,500.00	322,533,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,533,500.0	322,533,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,876,600.00	26,876,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,876,600.00	26,876,600.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,145,000.00	5,192,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,145,000.00	5,192,410.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,814,512.13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,116,303.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,116,303.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,016,303.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,033,617.00
210101	Үндсэн цалин	444,062.00
210104	Урамшуулал	3,589,555.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,494,981.00
210201	Тэтгэврийн даатгал	1,494,981.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,800.00
210301	Гэрэл, цахилгаан	10,800.00
210303	Цэвэр, бохир ус	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,355,500.00
210401	Бичиг хэрэг	194,500.00
210402	Тээвэр, шатахуун	961,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	442,500.00
2105	Нормативт зардал	35,064,148.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,566,048.00
210502	Хоол, хүнс	1,998,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	634,200.00
210604	Урсгал засвар	634,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,123,057.00
210702	Дотоод албан томилолт	1,123,057.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,170,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	670,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,201,057.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,201,057.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,866,057.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	775,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	48,560,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	3,084,754.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,084,754.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төв нь "Үйлчлүүлэгчдэд ээлтэй, сэтгэлд хүрсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламжийг жигд, хүртээмжтэй хүргэх" байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 352.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 545.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөг, 80 хувь буюу 8.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон байна. Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.2 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 6.1 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалаас цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41.7 сая төгрөг болж 12.0 сая төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар ирсэн бараа материалтай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 90.0 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 72.0 сая төгрөгийн бараа

материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 149.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 42.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 740.6 сая төгрөг болж 39.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 35.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 0.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас акталсантай холбоотой байна. Тайлант оны эцэст 740.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэн нь үлдэх өртгийг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 526.3 сая төгрөг болж 6.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 41.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 442.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 365.6 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 77.0 сая төгрөгөөр буурсан нь хөдөө орон нутагт ажилласан тэтгэмжийг аймгийн Эрүүл мэндийн газраас олгохоор болсонтой холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 365.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 354.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 351.8 сая төгрөгийг зарцуулж 2.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 351.8 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь 2.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 72.2 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 69.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.1 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, худалдан авалтын И баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 352.0 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулахаас 352.0 сая төгрөгийн 171 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 13.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.9.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 1.4 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох

хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн 1.2 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгуулах 3.1 сая төгрөгийн албан шаардлагын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.1 сая төгрөгийг залруулан, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Хүнсний материалын тооцоог хийхэд 0.6 сая төгрөгийн материалын зарцуулалтыг анхан шатны баримтгүйгээр шууд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтгүйгээр 0.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Татварын тодорхойлолтоор 0.2 сая төгрөгийн 5 нэр төрлийн татварын өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,

баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- И баримтгүй 1.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 13.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

• 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайшир сумын ЭМТ	4	17.5	1	2.1	1	0.7	3	14.7	0.0	0.0